



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/31

Мандалговь

Цахим уралдааны зардал гаргах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.2, 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлогын баримт бичиг батлах тухай" 2018 оны 03 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Агентлагын даргын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/125, 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/155 дугаар тоот чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн орчинд хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, хүүхдийн санал санаачлагыг дэмжих зорилгоор "Миний гэр бүл-Аюулгүй орчин", "Бүтээлч хүүхэд" цахим уралдаануудыг зохион байгуулсугай.

2. Цахим уралдаан зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар, бүртгэлийн хуудсыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 409.000 (Дөрвөн зуун есөн мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн (Б.Цэцэг)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн (Б.Цэцэг), гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Ц.ГАНЗОРИГ



431190057